

ГАРЧИГ

<i>НЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	2
1.1. <i>Төслийн төлөвлөлт, ажиллах хүч</i>	4
<i>ХОЁР. ТӨСЛИЙН БАЙРШИЛТАЙ ХОЛБОГДОХ НӨЛӨӨЛӨЛ</i>	4
<i>ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	5
<i>ДӨРӨВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	12
<i>ТАВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	18
<i>ЗУРГАА. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	19
<i>ДОЛОО. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	22
<i>НАЙМ. ТУХАЙН ЖИЛИЙН ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ</i>	28
<i>ЕС. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	31
<i>АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАСАН БАЙДАЛ</i>	32
<i>ДҮГНЭЛТ</i>	32

НЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. Төслийн ерөнхий мэдээлэл

Үндсэн үзүүлэлтүүд	Тайлбар
Төслийн нэр	“Шохой болон хөнгөн бетон үйлдвэрлэх үйлдвэр”
Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	“Силикат” ХК
Төсөл хэрэгжүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээ, регистрийн дугаар	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 1910010007 Регистрийн дугаар: 2050463 Харилцах утас: 99053180, 99053485
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р баг, Үйлдвэрийн район, өөрийн байр.
Төслийн байршил	Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт 43736.0 м ² талбайд хэрэгжинэ.

Төслийн байршил: Уг “Хөнгөн бетон блок, шохойн үйлдвэр” нь Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт газар эзэмших эрхийн 0079244 тоот гэрчилгээ бүхий 43736.0 м² талбайд хэрэгжинэ.


Хүснэгт 2. Төсөл хэрэгжих талбайн солбицол

№	Хойд өргөрөг	Зүүн уртраг
1	49° 26' 10.537"	105° 57' 55.971"
2	49° 26' 3.736"	105° 58' 2.756"
3	49° 26' 2.303"	105° 57' 59.274"
4	49° 26' 0.482"	105° 57' 54.604"
5	49° 26' 0.827"	105° 57' 54.296"
6	49° 26' 4.359"	105° 57' 50.835"
7	49° 26' 4.754"	105° 57' 51.820"
8	49° 26' 4.818"	105° 57' 51.980"
9	49° 26' 5.002"	105° 57' 52.439"
10	49° 26' 5.134"	105° 57' 52.767"
11	49° 26' 5.234"	105° 57' 52.666"
12	49° 26' 6.823"	105° 57' 51.048"
13	49° 26' 6.459"	105° 57' 50.169"
14	49° 26' 6.563"	105° 57' 50.069"
15	49° 26' 6.752"	105° 57' 49.886"
16	49° 26' 7.509"	105° 57' 49.157"
17	49° 26' 7.633"	105° 57' 49.034"



Төслийн талбайн байршил

Дархан-Уул аймаг, Дархан сум.



Зураг 1. Төслийн байршилын зураг

“Силикат” ХК-ийн товч танилцуулга

- ✓ 1966 онд “Силикат тоосго, шохойн үйлдвэр” нэрээр Дархан хотын анхны аж үйлдвэр болон баригдаж баригдсан.
- ✓ 1966 оноос 1992 он хүртэл тасралтгүй ажилласан ба тухайн үеийн Монгол улсын ханын материалын хэрэгцээний 25%ийг дангаар хангаж байсан түүхтэй.
- ✓ 2004 онд Ц.Содбилэг нь “Силикат”ХК-ийг худалдан авч 2006 онд силикат цагаан тоосгоны дамжлагыг Силикат хөнгөн блокны үйлдвэр болгон шинэчилсэн.
- ✓ Силикат шохойн үйлдвэрийг бүрэн сэргээн засварлаж шинэчилж, үйлдвэрлэлээ явуулж ирсэн.

1.1.Төслийн төлөвлөлт, ажиллах хүч

Хөнгөн бетон блокны үйлдвэр

Хөнгөн блок нь 360 х 180 х 600 ба 360 х 240 х 600 гэсэн хэмжээтэйгээр хоногт 150 м³, жилд 40000 м³ хөнгөн бетон блок үйлдвэрлэх хүчин чадалтай. Бэлэн бүтээгдэхүүний талбайг 4000 м³ хөнгөн блокоор жил бүрийн өвөл 10-12 сарын хооронд дүүргэдэг.

Цахилгаан хангамж

150 мм-н диаметртэй өндөр даралтын уурын шугамаар ДДЦС ТӨХК-тай холбогдсон. 6000/400кВа цахилгаан дэд станцтай.

Усан хангамж

Усны эх үүсвэр

Төвийн дулаан, цэвэр бохир усны шугамд холбогдсон болно.

2023 онд 10000 м³ хөнгөн бетон блок үйлдвэрлэн Дархан Уул аймаг төдийгүй Эрдэнэт, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ зэрэг төвийн бүсийн бүхий л хэрэглэгчдэд авто замаар болон төмөр замаар тээвэрлэн нийлүүлж байна.

ХОЁР. ТӨСЛИЙН БАЙРШИЛТАЙ ХОЛБОГДОХ НӨЛӨӨЛӨЛ

Төсөл хэрэгжих байршлын хувьд хүн амыг нүүлгэн шилжүүлэх, түүх соёлын археологийн олдворт газарт ямар нэгэн нөлөөлөл байхгүй.

ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг	Төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдал
Агаар орчин				
Тоосжилт үүсэх	Тоосжилтын хяналтыг тоосжилт үүсэх эх үүсвэрүүд болон ажлын байранд тогтмол хийж, ихэссэн үед нь холбогдох арга хэмжээ авч байх	Төсөл хэрэгжих хугацаанд	300.0	Тоосжилтын хяналтыг ажлын байранд тогтмол хийж, түүхий эд тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь тоосжилт үүсэхээс сэргийлж хучлагатай тээвэрлэлт хийн ажиллаж байгаа.
	Түүхий эд тээвэрлэхдээ асгарах, тоосрохоос хамгаалсан хучлагатай байх	Төсөл хэрэгжих хугацаанд	Үйл ажиллагааны зардлаас	
	Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүд оношлогоог тогтмол хийлгэх	Төсөл хэрэгжих хугацаанд	500.0	
Хөрс, ургамал				
Ажилчдын оффис, үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдал нь хөрс бохирдуулах	Хог хаягдлыг тухай бүрт нь ангилан зайлуулах арга хэмжээ авах	Төсөл хэрэгжих хугацаанд	Хог хаягдлын зардалд тусгагдсан.	Дархан Уул аймгийн Хот тохижуулах компанитай жил бүр гэрээ хийж хог хаягдалыг тухай бүрт татан зайлуулж ажилласан.
Бусад асуудлаар				
Байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, стандартын хэрэгжилтийг хянах	Байгаль орчны аудит хийлгэж Аудитын дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ.	Аудитыг төслийн 2 дахь жилээс хийлгэх	Байгаль орчны аудитын төлөвлөгөөнд тусгасан.	Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж дүгнэлт гаргуулсан
Сонирхогч талуудын оролцоог хангах	БОННУ тайлан болон БОМТ-г Орон нутгийн холбогдох байгууллагууд, иргэдэд тайлагнах ажил зохион байгуулах	Жилд 1-2 удаа	Үйл ажиллагааны зардлаар	Тайлагнан ажилласан.

ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2023 оны 07-р сарын 05 өдөр

№

Улаанбаатар хот

Нэг талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 13-р хороолол, Юнескогийн гудамж –31, Далай Тауэр, 402 тоотод тоотод байрлах Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан “Энвайронментал комплайнц” ХХК (цаашид “Компани эсхүл Гүйцэтгэгч” гэх), түүнийг төлөөлж захирал Б.Энхбаяр,

нөгөө талаас Монгол улс, Дархан Уул аймаг, Дархан сумд байрлах, Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан “Силикат” ХК (цаашид “Захиалагч”), түүнийг төлөөлж захирал Ц.Содбилэг бид нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 зүйлүүдийг үндэслэн дараах нөхцөл бүхий гэрээг харилцан тохиролцож (цаашид “Гэрээ” гэх) байгуулав

1. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭ

1.1. Гэрээлэгч нь Захиалагчийн Дархан Уул аймаг Дархан суманд байрлах “Силикат” ХК-д “Байгаль орчныг хамгаалах тухай хууль” –ийн 10¹ дугаар зүйлд заасны дагуу байгаль орчны хууль тогтоомжийн нийцлийн аудит хийж, улмаар төслийн одоогийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх, засаж сайжруулах зүйлс, авах арга хэмжээ, цаашид байнгын сайжруулах боломж бий болгож улмаар Захиалагчид учирч болзошгүй эрсдэл, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх болон орон нутгийн иргэд, ажилчдын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бий болгоход нь тусалж дүгнэлт, зөвлөмж өгөх нь энэхүү аудитын ажлын үндсэн зорилго оршино.

1.2. **Үйлчилгээний тайлбар:** Байгаль орчны төлөвлөгөөт аудит

1.3. **Байршил** Дархан Уул аймаг Дархан сум “Силикат” ХК

1.4. **Үйлчилгээ үзүүлэх гэрээний:**

Эхлэх хугацаа: 2023 оны 07-р сарын 05-ний өдөр /БОА-н үйлчилгээ гэрээний урьдчилгаа төлбөр төлөгдсөн өдрөөр эхлэнэ./

Дуусах өдөр: 2023 оны 07-р сарын 30-ны өдөр хүртэл.

1.5. **Гүйцэтгэх ажлын үндсэн чигэл:**

1.5.1. Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2019.12.25-ний өдрийн А/809 тушаалаар батлагдсан Байгаль орчны аудит хийх журмын дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэх,

- 1.5.2. Төслийн талбай дээр биечлэн ажиллаж нөхцөл байдалтай танилцах, төслийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны бичиг баримтын бүрдэлтэй танилцах, шалгах,
- 1.5.3. БОНБУ-ний тайлангийн хэрэгжилтийн биелэлт буюу нийцлийн үнэлгээ хийх,
- 1.5.4. МУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж буй байгаль орчны хууль, тогтоомж, стандарт, дүрэм журам, бодлогын бичиг баримтын хэрэгжилтийг уурхайн үйл ажиллагаатай уялдуулан хянаж, үл нийцлийг илрүүлэх, цаашид авах сайжруулах арга хэмжээг төлөвлөх, зөвлөмж боловсруулан, дүгнэлт гаргах.
- 1.5.5. Хууль тогтоомжид заасан бусад.

Компанийн үүрэг, хариуцлага

- 1.6. Компани нь Байгаль орчны аудитын зөвлөх үйлчилгээг сайдын 2019.12.25-ний өдрийн А/809 тушаалаар батлагдсан Байгаль орчны аудит хийх журам, Монгол Улсын холбогдох хууль, дүрэм, журам болон Захиалагчаас тавьсан шаардлагад нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд чанартай хийж гүйцэтгэнэ.
- 1.7. Компани нь захиалагчийн үйл ажиллагаа болон хэрэгжүүлж буй хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахын тулд бичиг баримтын аудит, нотлох баримт цуглуулах болон холбогдох ажилчидтай уулзалт хийнэ.
- 1.8. Компани нь Захиалагчийн төслийн талбайд ажиллаж бичиг баримтаар цуглуулсан мэдээллийг нягтлах ажиглалтын мэдээ цуглуулах ба мөн төслийн үйл ажиллагаатай танилцана.
- 1.9. Компани нь Байгаль орчны аудитын явцад цуглуулсан бичиг баримт, нотолгоо, мэдээлэл дээр үндэслэн аудитын дүгнэлт, зөвлөмжийг гаргана.
- 1.10. Гүйцэтгэгчийн ажилчид нь Гэрээт ажлыг гүйцэтгэх хангалттай дадлага туршлагатай мэргэжлийн хүмүүс байх ба Гэрээт ажлыг гүйцэтгэх явцдаа Захиалагч болон Гуравдагч этгээдэд хохирол учруулсан тохиолдолд хохирлыг бүрэн хариуцна.
- 1.11. Захиалагчийн ажлын байрны онцгой нөхцөл байдлыг дээд зэргээр анхааран ажлын байранд элдэв зөрчил гаргахгүй, Захиалагчийн өдөр тутмын ажил болон түүний гэрээлэгч, гуравдагч этгээдийн ажилд саад учруулахгүйгээр Гэрээт ажлыг гүйцэтгэх үүрэгтэй. Энэ үүргээ зөрчсөнтэй холбогдох хариуцлагыг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.
- 1.12. Гүйцэтгэгч нь ажлын талбайг дүрэм журам, стандартын дагуу зөв зохион байгуулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн

шаардлагыг ханган ажиллах үүрэгтэй бөгөөд энэ үүргээ зөрчсөнтэй холбогдох хариуцлагыг Гүйцэтгэгч тал хүлээнэ.

Захиалагчийн үүрэг, хариуцлага

- 1.13. Захиалагч нь Байгаль орчны аудит хийх бүхий боломжийг компанид гаргаж өгнө.
- 1.14. Захиалагч нь төслийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны өөрт байгаа бичиг баримт, нотлох баримтуудыг ажлын байранд бэлэн байлгаж аудитын хөтөлбөрийг цаг алдалгүй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- 1.15. Гэрээт ажлын явцад өөрийн нутаг дэвсгэр, үйлдвэр объект, ажлын байранд чөлөөтэй нэвтрүүлэн, дээж, сорьц авах, хэмжилт хийх, холбогдох бусад мэдээллийг цуглуулах бололцоогоор хангана.
- 1.16. Аюулгүй ажиллагааны нэг бүрийн хамгаалах хувцас, хөдөлмөр хамгааллын хэрэгслийг бүрэн хангана.
- 1.17. Захиалагч нь өөрийн төслийн хэмжээнд мөрдөгдөж буй дүрэм журмыг танилцуулж, Аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулж, аюулгүй, ажлын бүтээмжтэй ажиллах нөхцлийг хангана.

2. ТӨЛБӨР ТООЦОО:

- 2.1. Байгаль орчны аудитын үйлчилгээний зардал нь аливаа татвар хураамж (НӨАТ тооцогдоогүй болно) багтсан дүнгээр **1 500 000 /Нэг сая таван зуу мянга / төгрөг** болно.
- 2.2. Гэрээний үнэд аудитын үйлчилгээ, холбогдох судалгаа хийх, дүгнэлт гаргах, тайлан боловсруулах, удирдлага, зохион байгуулалт багаж хэрэгсэл ашиглах үнэ, Улаанбаатар хотоос төслийн талбай хүртэлх тээврийн зардал, холбогдох татвар хураамж, Гүйцэтгэгчийн ажиллагсдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар, болзошгүй бусад зардал зэрэг Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардагдах бүхий л зардлууд багтсан болно.

3. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 3.1. Гэрээний үнийг Захиалагч дараах хуваарийн дагуу төлнө. Үүнд:
 - 3.1.1 Талууд гэрээг байгуулан баталгаажуулсан өдрөөс хойш ажлын 3 хоногт гэрээний урьдчилгаа төлбөр болгон гэрээний үнийн **50 хувь буюу 750**

000 /Долоон зуун тавин мянга/ төгрөгийг Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн түүний дансанд шилжүүлнэ.

3.1.2 Гүйцэтгэгч тал гэрээгээр тохирсон үүргээ бүрэн биелүүлж, Захиалагчид танилцуулан Гэрээт ажлын үр дүнг хүлээлгэж өгснөөс хойш ажлын 5 хоногт багтаан үлдэгдэл төлбөр буюу гэрээний үнийн **50 хувь буюу 750 000/ Долоон зуун тавин мянга/** төгрөгийг Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн шилжүүлнэ. Үлдэгдэл төлбөр шилжсэний дараа Экологийн хариуцлагын гэрээг байгуулна.

3.2 Төлбөрийг Төрийн банк, 104 100 628 173 (MNT) тоот дансанд шилжүүлнэ.

4. ХАРИУЦЛАГА.

4.1. Аль нэг тал энэ гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсвэл ийнхүү биелүүлэх боломжгүй гэдэг нь нэгэнт тодорхой болсон, Гэрээт ажлыг дараалан 20 хоног, эсвэл нийт 30 хоног хойшлуулсан, аль нэг тал нь дампуурсан эсвэл бусдад эрхээ шилжүүлсэн тохиолдолд тухайн хохирогч талын санаачилгаар гэрээг цуцална.

4.2. Энэхүү гэрээнд заасан төлбөрийн хугацааг хэтрүүлбэл хоног тутамд гүйцэтгээгүй төлбөрийн 0,5 хувьтай тэнцэх алдангийг төлбөрийн хамт төлөх хариуцлага хүлээнэ.

4.3. Аль нэг талын буруугаас гэрээг цуцалсан тохиолдолд учирсан шууд болон шууд бус аливаа хохирлыг буруутай талаар нөхөн төлүүлнэ.

5. ЭКОЛОГИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

5.1. Талууд энэхүү гэрээг байгуулж, Гүйцэтгэгч зөвлөмж, дүгнэлтээ Захиалагчид хүлээлгэн өгсөний дараа “Экологийн хариуцлагын гэрээ” –г холбогдох хууль, дүрэм, журмын дагуу байгуулж ажиллана.

6. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ.

Ажил гүйцэтгэх явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах, нэмэлт гэрээ байгуулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

7. БУСАД:

7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад гарсан маргаантай асуудлыг хоёр тал эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол


асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

- 7.2 Талууд энэхүү гэрээг 2% үйлдэж Захиалагч 1 хувь, Компани 1 хувийг хадгалах бөгөөд гэрээний хувиуд хуулийн адил хүчинтэй байна.
- 7.3 Ажил гүйцэтгэгч нь ажил үүрэг гүйцэтгэх хугацаандаа болон гэрээ дуусгавар болсны дараа гэрээнд тусгайлан заасан хугацааны турш олж мэдсэн, танилцсан аливаа мэдээ, мэдээлэл, бичиг баримт бизнесийн үйл ажиллагааны нууцыг задруулахгүй чанд хадгална. Захиалагчийн нууц мэдээ, мэдээлэлд ажил хэрэгтэй холбоотой санхүүгийн, геологийн, хуулийн гэрээтэй холбоотой баримт бичиг, объект, үйл ажиллагааны талаарх мэдээ, зураг, тооцоо зэрэг нь “Нууц мэдээлэлд” хамаарна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

КОМПАНИ

Захирал Б.ЭНХБАЯР



Утас 99083500

ЗАХИАЛАГЧ

Захирал Ц.СОДБИЛЭГ



Утас 99053180

Зураг 2. Байгаль орчны аудит хийлгэх ажил гүйцэтгэх гэрээ

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Силикат ХХК-ийн блокийн үйлдвэрийн үйл ажиллагаанд “Байгаль орчныг хамгаалах тухай хууль” –ийн 10¹ дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчны багц хуулиуд тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, тогтоол, байгаль орчны стандартуудын заалтуудын нийцлийн аудитыг 2023 оны 08-р сарын 10-20 өдрүүдийн хооронд хийж гүйцэтгэв.

Тус төслийн байгаль орчны аудитыг БОННУ болон бусад БО-ны баримт бичгүүдийн хяналт, төслийн талбай дээрх шалгалт, холбогдох ажилтнуудтай хийсэн ярилцлага болон цуглуулсан баримт нотолгооны дээр үндэслэн аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулах зэрэг үндсэн үйл ажиллагааны дагуу хийв.

Силикат ХХК-ийн блокийн үйлдвэрийн төсөл нь Байгаль орчны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажилд анхаарал тавьж байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэж байгаа нь сайшаалтай байлаа. Мөн байгаль орчныг хамгаалахад маш их сэтгэл гаргаж ажилладаг нь үйлдвэрийн орчин, эмх цэгцтэй байдал, бичиг баримтын бүрдэл зэргээс тодорхой харагдаж байлаа.

Төслийн үйл ажиллагаанууд нь хууль эрх зүйн хувьд нийт 24 хуулийн 295 зүйл заалтаас хамаарал бүхий 134 зүйл заалтын хэрэгжилтийг шалгахад нийцлийн 134 заалт буюу 100% байлаа.

Аудитын хугацаанд үйлчлүүлэгч байгууллагын холбогдох ажилтнууд дэмжин хамтран ажилласан бөгөөд ямар нэгэн саад тотгор, хөндлөнгөөс нөлөөлөх байдал гараагүй болно.



Гарын үсэг:

Огноо: 2023.08.15

Б.Энхбаяр, Ахлах аудитор

Зураг 3. Байгаль орчны аудитын дүгнэлт

ДӨРӨВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөгөөр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд оролцож, “Силикат” ХК-ийн эзэмшлийн Сайханы элс нэртэй талбайд 624 ш хайлаас модыг тарьж суулгасан.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

№ _____

ДАРХАН-УУЛ АЙМАГ
(аймаг, сум, дүүрэг)

2023 оны 10 дугаар
сарын 03-ны өдөр

Нэг талаас : Дархан-Уул аймгийн Дархан сум 13 баг Үйлдвэр районд байрлах Силикат ХК (цаашид “Захиалагч гэх”) түүнийг төлөөлж захирад Ц.Содбилэг

Нөгөө талаас : Дархан хотын тохижилт үйлчилгээний газар ОНӨААТҮГ (цаашид “Ажил гүйцэтгэгч гэх”) түүнийг төлөөлөн дарга З.Эрдэнэбат нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон дараахь гэрээг харилцан тохиролцож байгуулав.

1. Нийтлэг заалт

- 1.1. Гүйцэтгэгч нь захиалагчийн даалгаврын дагуу, түүний материалаар (эсвэл өөрийн материалаар) Захиалагч талаас зааж өгсөн газар буюу Сэлэнгэ аймгийн Сайхан сум Номгон тосгон Сайханы элс гэх газарт 78 метр газарт 624 ширхэг халайст мод тариулах хийж 2023 оны 10 дугаар сарын 16 ны өдрийн дотор хугацаанд нь гүйцэтгэж захиалагчийн өмчлөл буюу эзэмшилд шилжүүлнэ.
- 1.2. Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч, хөлсийг гэрээгээр тохиролцсон хэлбэр, хугацаанд төлнө.

2. Гэрээний хугацаа

- 2.1. Ажил гүйцэтгэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоох бөгөөд календарийн тооллыг удирдлага болгоно.
- 2.2. Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа 14 хоног
- 2.3. Ажил эхлэх хугацаа 2023.10.03
- 2.4. Ажил дуусах хугацаа 2023.10.16

3. Ажлын хөлс

- 3.1. Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс 2.415.000 /хоёр сая дөрвөн зуун арван таван мянган / төгрөг ба захиалагч ажил гүйцэтгэж нар харилцан тохиролцож 1 метр кубын 239.900 төгрөгний үнэ бүхий хөнгөн бетон блокыг 10.06 метр кубээр тооцож олгохоор тохиролцов.
- 3.2. Гэрээнд заасан хугацаанд төлбөрөө буюу хөнгөн бетон блокыг аль үед авч болхоор харилцан тохиролцов.

4. Захиалагчийн эрх, үүрэг

- 4.1. Ажил гүйцэтгэхэд шаардагдах дэмжлэг дуслалцааг гүйцэтгэгч талд үзүүлнэ.
- 4.2. Ажил гүйцэтгэгч үүргээ биелүүлэхэд шаардагдах бичиг баримт болон бусад мэдээллийг өгнө.

- 4.3. Гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол байвал ажил хүлээн авснаас хойш 6 сарын дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.
- 4.4. Гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч хөлсийг саадгүй төлөх үүрэгтэй.

5. Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 5.1. Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ.
- 5.2. Ажлыг биечлэн гүйцэтгэнэ.
- 5.3. Ажил гүйцэтгэхээр захиалагчаас авсан материалын зарцуулалтын талаар захиалагчид тайлагнаж, үлдэгдэл материалыг ажил дууссаны дараа захиалагчид буцаан өгнө.
- 5.4. Захиалагчийн өгсөн материал чанар, стандартын хувьд ажлын шаардлага хангахгүй бол түүнийг сольж өгөхийг шаардах эрхтэй.
- 5.5. Захиалагч ажлын үр дүнг хугацаанд нь авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцож хөлс төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.

6. Талуудын хүлээх хариуцлага

- 6.1. Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа сунгах болсон шалтгааныг үндэслэлтэй тайлбарлана.
- 6.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.
- 6.3. Торгууль, алданги төлсөн нь материалыг устгасан, гэмтээснийг нөхөн төлөх үүрэг гүйцэтгэхээс чөлөөлөгдөхгүй.

7. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт , үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / - ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.
- 7.2. Дээрхи давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

8. Бусад заалт

- 8.1. Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 8.2. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 8.3. Талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Үндэсний Арбитрт түүний Арбитрын Хэрэг Шийдвэрлэх Дүрмийн дагуу Монгол Улсад Эцэслэн шийдвэрлүүлнэ.

9. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам

9.1. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

10. Нэмэлт нөхцөл

10.1 Ажил хийж гүйцэтгэсэний дараа 6 сарын хугацаанд үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэж бараа материалаас бусад гэмтэлийг гүйцэтгэгч хариуцаж ажиллах.

11. Талуудын хаяг

Захиалагч:

Хаяг: Дархан-Уул аймгийн Дархан сум Силикат ХК-ний захирал Ц.Содбилэг

Регистер: 2050463

Утас: 99053485

Гарын үсэг:



(Тамга, тэмдэг)

Гүйцэтгэгч:

Хаяг: Дархан-Уул аймгийн Дархан сум Өргөө баг Дархан хотын тохижилт үйлчилгээний газар ОНӨААТҮГ-ын дарга З.Эрдэнэбат

Регистер: 4289269

Утас: 99399453

Гарын үсэг:



(Тамга, тэмдэг)


Эдийн засагч Т.Амгаланбаатар

Утас : 99399453

Гарын үсэг :

- а Мунг

Зураг 4. Мод суулгах ажил гүйцэтгэх гэрээ

 ХААН БАНК		Огноо/Date: 2023.10.31 14:05:01		
Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information				
Журналын/Journal No: 35814276				
Системийн огноо/System Date: 2023.10.13 17:15:47				
Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number 5086046007	Нэр/Name В****Я МӨНХТУЯА	Дүн/Amount 300,000.00 MNT	Ханш/Rate 1.00
/ Гурван зуун мянган төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No 05 Дансны/Картын дугаар Account/Card number 5163133642	Банкны нэр Bank Name Хаан банк Нэр/Name С*****Г ЗОЛБООТӨГС	300,000.00 MNT	1.00
Гүйлгээний утга/Transaction description: Мод тор татуулах төлбөр				

Зураг 5. Мод суулгах ажлын төлбөр төлсөн баримт





Зураг 6. Мод суулгаж буй явц



Зураг 7. Мод суулгаж буй явц

ТАВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйлдвэрийн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол үйлдвэрийн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

ЗУРГАА. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд үйлдвэрийн байранд галын булан байрлуулж, галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулсан. Түүнчлэн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж батлуулсан.



Зураг 8. Галын аюулгүй байдлын дүгнэлт



Зураг 9. Галын булан

БАТЛАВ.
СИЛИКАТ ХК-ИЙН
ЗАХИРАЛ *С. Ц. Сүх* Ц.С.ОДБИЛЭГ




СИЛИКАТ ХК-ИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

ХЯНАСАН:
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ГАМШГААС ХАМГААЛАХ
ТӨЛӨВЛӨЛТ БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ,
ХОШУУЧ Н.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:
ХАБЭА ИНЖЕНЕР *А.Агваандорж* А.АГВААНДОРЖ

Зураг 10. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө

ДОЛОО. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

<p>БАТЛАВ: “ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР”-ЫН ДАРГА  3.ЭРДЭНЭБАТ</p>	<p>БАТЛАВ: ДАРХАН-УУЛ АЙМАГ “СИЛИКАТ ХК”-НИ САХИАЛАГЧ ДАРГА/   4515207260 4515207260</p>	
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ		
2022 оны 12 сар 1 өдөр	№ 95	Дархан-Уул аймаг

Иргэн, ААН байгууллагын нэр	"Силикат" ХК.	
Регистрийн дугаар	2020463.	
Үйл ажиллагааны чиглэл	Нөмрөн бетон блок.	
Иргэн, ААНБ-ын хаяг	13-р баг	
ААНБ-ын холбогдох утас	99053180- орон заагаагч.	
Данс	5108367520- нөмрөн банк. 100130100947- төрийн сн.	
Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төрөл	Сард 100000.....төгрөг	Рейсийн тоогоор 1 рейс Төгрөг
Төлбөрийн нөхцөл	4 - 11 сар.	
Гэрээний хугацаа	2022 оны 12-р сарын 1-ны өдрөөс 2023 оны 12-р сарын 1-ны өдөр хүртэл	
Гэрээний сунгалт		

Гүйцэтгэгч талаас “Дархан Хот Тохижилт Үйлчилгээний Газар” ОНӨААТҮГ-ыг төлөөлж Ахлах байцаагч Даш-ёндон овогтой Нарантуяа Нөгөө талаас
В.овогтой.....Монгол улс...../цаашид захиалагч тал гэх/ нар нь "Монгол Улсын Хог Хаягдлын тухай хууль", "Зөрчлийн тухай хууль" эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудыг үндэслэн харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээний зорилго нь гүйцэтгэгч тал нь ААНБ-аас гарч байгаа ахуйн болон аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг гэрээнд заасан хугацаанд ачиж тээвэрлэх түрж булж устгах, захиалагч тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

Хоёр. Гүйцэтгэгч талын эрх үүрэг

- 2.1 Захиалагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй
- 2.2 Хог хаягдал тээвэрлэсний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах эрхтэй
- 2.3 хог тээврийн машин орж ачих боломжгүй байршилд байгаа, тогтоосон цэгт төвлөрүүлээгүй, хог тээврийн хураамжаа тайлант хугацаанд төлөөгүй, хуримтлагдсан өртэй ААНБ-ын хог хаягдлыг ачиж тээвэрлэхгүй байх эрхтэй.
- 2.4 Хог хаягдлын тухай хууль тогтоомжуудыг үндэслэн хог хаягдлаа ачиж тээвэрлүүлэх, зориулалтын зөвшөөрөгдсөн цэгт хаяхыг шаардах эрхтэй
- 2.5 хог хаягдлыг дуудлагаар буюу графикт хугацаанд гэрээний дагуу ачих үүрэг хүлээнэ.
- 2.6 Ажлын ачаалал, цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч графикт хугацаанд хогийг ачиж тээвэрлэж чадахгүй бол урьдчилан мэдэгдэнэ.

Гурав. Захиалагч талын эрх үүрэг

- 3.1 Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 3.2 Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх, хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах эрхтэй.
- 3.3 Хог хаягдлын тооцоог сар бүрийн 25ны дотор тооцоо нийлж тухайн сард багтээн төлбөрийг барагдуулах үүрэг хүлээнэ.
- 3.4 Хог хаягдлаа ачиж тээвэрлэх захиалга өгсөн үед тээврийн хэрэгсэл очиход хариуцсан ажилтнаа байгууллага дээрээ байлгаж, хог ачилтанд хяналт тавих үүрэг хүлээнэ.
- 3.5 ААНБ-ууд нь хог хаягдлыг саадгүй ачих нөхцлийг бүрдүүлсэн байх, тохиромжтой, стандартын хогийн савтай байх
- 3.6 Хог хаягдлын талаархи хууль тогтоомж, стандартын шаардлагыг ханган ажиллах

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1 Энэхүү гэрээний 3.2-д заасан хугацаанд захиалагч тал үйлчилгээний төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам үнийн дүнгийн 0.2 хувиар алданги тооцож төлнө.
- 4.2 Нийтийн эдэлбэр газар болон ногоон бүсэд хог хаягдал хаясан иргэн, ААН-ийн зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл хураах, унаа хөсөг, техник тоног төхөөрөмжийг хурааж, "Зөрчлийн тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 1,2,3,4,5,6т зааснаар зөрчил гаргасан хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 4.3 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх болон хүчин төгөлдөр байх хугацаанд гарч болох бүх маргаан зөрчил зэргийг харилцан тохиролцож шийдвэрлэх ба үл тохиролцсон тохиолдолд Монгол улсын хуулийн дагуу тухайн бүс нутагийн харьяалах шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 4.4 Гэрээг 2 хувь үйлдэж гэрээнд эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

Тав. Нэмэлт заалт

.....
.....
.....
.....

ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗАР ОНӨААТҮГ-ЫГ ТӨЛӨӨЛЖ:

ЭДИЙН ЗАСАГЧ
Т. АМГАЛАНБААТАР

АХЛАХ БАЙЦААГЧ
Д. НАРАНТУЯА
Утас: 88283004

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

Албан тушаалт
Орлогч Захиалагч
СИЛИКАТ
Албан тушаалт
ХК
В. МОНХТУША
Утас: 990521180 2050463

Зураг 11. Хог хаягдлын гэрээ

Огноо/Date: 2023.09.27 10:27:37

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
 Журналын/Journal No: 7010263

Системийн огноо/System Date: 2023.09.27 10:27:37

Дт/From	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5086105463	СИЛИКАТ	400,000.00 MNT	1.00
/ Дөрвөн зуун мянган төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No 05	Банкны нэр/Bank Name Khan Bank - Хаан банк	400,000.00 MNT	1.00
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number 5108367520	Нэр/Name ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР		

Гүйлгээний утга/Transaction description:
 ЕВ-Силикат ХК-с хог хаягдалын төлбөр 2050463

Огноо/Date: 2023.05.25 11:39:01

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
 Журналын/Journal No: 10861722

Системийн огноо/System Date: 2023.05.25 11:39:01

Дт/From	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5086105463	СИЛИКАТ	120,000.00 MNT	1.00
/ Нэг зуун хорин мянган төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No 05	Банкны нэр/Bank Name Khan Bank - Хаан банк	120,000.00 MNT	1.00
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number 5108367520	Нэр/Name ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР		

Гүйлгээний утга/Transaction description:
 ЕВ-Силикат ХК-с хог тээвэрлэлтийн төлбөр 2050463

Зураг 12. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт

“ДАРХАН-УС СУВАГ” ХК



**ЦЭВЭР УСААР ХАНГАХ,
БОХИР УСЫГ ТАТАН ЗАЙЛУУЛАХ,
ЦЭВЭРЛЭХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ГЭРЭЭ**

Нэр: *Сэлэнгэ (Сүхүүр)*.....
Код: *220016*.....

ДАРХАН-УУЛ АЙМАГ

*Дархан-Ус Суваг ХК-ийн Гүйцэтгэх захирал
 20... Оны ... дугаар сарын ... ны өдөр /... дугаар
 тушаалын хэвсрэлт

ОРОН СУУЦНЫ АЙЛ ӨРХ, АЖ АХУЙ НЭГЖИЙН ЦЭВЭР БОХИР УСНЫ
 ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ САНТЕХНИКИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР
 ҮЙЛЧИГЭЭНИЙ АЖЛЫН ДУУДЛАГААР ҮЙЛЧЛЭХ ҮНИЙН ТАРИФ

№	Засвар үйлчилгээний ажлын нэр	Тарифт үнэ /төг/		
		Айл өрх	Аж ахуй нэгж	Хувийн орон сууц
1	Угаалтуурын тосгуурын бөглөө гаргах	4000	5500	4000
2	Ванны бөглөө гаргах	4000	5500	4000
3	Тосгуурын сифон солих	3500	5000	3500
4	Ванны сифон солих	4000	6000	4000
5	Ванн солих	17000	25000	17000
6	Угаалтуур солих	8000	12000	8000
7	Суултуурын бөглөө гаргах	6000	7500	6000
8	Суултуурын холболт салгаж угсрах (солих)	9000	14000	9000
9	Суултуурын манжет резин солих	3000	4000	3000
10	Босоо шугамын бөглөө гаргах	7000	9000	8000
11	Ус жураагуурын эд анги солих (Бочки)	5500	7500	5500
12	Бохирын босоо шугам солих	17000	24000	20000
13	Ерөнхий вентил солих	7000	9000	8000
14	Давхар хоорондын цэвэр усны шугамын монтаж солих	22000	30000	20000
15	Тосгуурын сгон солих	4000	6000	4000
16	Босго шугамын сгон солих	5000	7000	5000
17	Ван ны холигч солих (ком)	7000	9000	7000
18	Тос уурын холигч солих	5000	7000	5000
19	Тосгуурын уян холбоос солих	2500	3500	2500
20	00-д уян холбоос солих	2500	3500	2500
21	Кабинтай душ угсрах	35000	45000	35000
22	Угвалгын машины холболт хийх	18000	25000	18000
23	Тосгуурын резин, хог шүүгч цэвэрлэх	2500	3500	2500
24	Тоосгон хана цөмлөж ухах	4000	5500	4000
25	Бетон хана цөмлөж, ухах	5500	7500	5500
26	Хүйтэн ус хаах /ахиаглаар, 1 цаг хаах/	8000	10000	8000
27	Дуудлагын хөлс /8.00-17.00/	2000	3000	3000
28	Дуудлагын хөлс /17.00-8.00/	4000	6000	4000
29	Ø1000 худаг цэвэрлэх	45000	45000	45000
30	Ø1500 худаг цэвэрлэх	50000	50000	50000
31	Ø2000 худаг цэвэрлэх	60000	60000	60000
32	Люк таг тавьж угсрах	30000	30000	30000

Жич: Ажлын бус цагаар үйлчилгээний хөлсийг 50% өсгөж тооцно
 Харилцах утас: 7533-3737

БАТЛАВ:

"Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт орших
 "Шохой болон хөнгөн бетон үйлдвэрлэх үйлдвэр" төслийн байгаль орчны менежментийн
 ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИСЛЭЛТИЙН ТАЙЛАН

"ДАРХАН-УС СУВАГ" ХК
 БАТЛАВ:
 СИЛИКАТ ХК
 Эрденэбат

**ЦЭВЭР УСААР ХАНГАЖ, БОХИР УСЫГ ТАТАН ЗАЙЛУУЛАХ,
 ЦЭВЭРЛЭХ АЖ АХУЙ НЭГЖИЙН ГЭРЭЭ**

№.....

Нэг. Ерөнхий зүйл
 Монгол Улсын Иргэн хууль, Усны тухай хуулийн 16, 17, 19, 20, 22, 28-р зүйл, "Хот суурины ус хангамжийн ашиглалтын тухай хууль", "Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2017 оны 05 сарын 19-ний өдрийн 74 дүгээр тогтоолын "Тус зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм"-ийг үндэслэн хангагч гэр нэрлэгдэх "Дархан-Ус суваг ХК-ийн гэрээ хяналтын инженер ажилтай гэр нэрлэгдэх" хэрэглэгч гэж нэрлэгдэх-ыг төлөөлж, нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулах.

1.1. Энэхүү гэрээг усан хангамж, ариутгах татуургын сүлжээнээс цэвэр ус авч, бохир ус шууд болон автомашинаар нийлүүлдэг Улсын үйлдвэрийн газар, компани, бүх аж ахуй нэгж, орон сууцны нэг давхарын аж ахуйн байгууллагуудтай гэрээ хийж ажиллана.

1.2. Хэрэглэгч гэрээ байгуулахдаа дараах материалыг бүрдүүлж авч ирнэ.
 Үүнд:
 а. ААН-ийн гарчилгээ, Эзэмшигчийн иргэний үнэмлэх /хуулбар/
 б. Байгууллагын тамга тэмдэг
 в. Үйл ажиллагааны чиглэл, Үйлдвэрлэл үйлчилгээний хүчин чадал, ажиллах хугацаа
 г. Цэвэр усны болон бохир ус татан зайлуулах шугам сүлжээний заагийн схем
 д. Тухайн байгууламжийн байршилийн зураг /4 талаас/
 е. Гэрээний дэвтэр

1.3. Хангагч тал хэрэглэгчтэй жил бүр цэвэр усаар хангуулах, бохир ус татан зайлуулах гэрээг байгуулж, дүгнэж тодотголыг бичнэ.

1.4. Гэрээт хугацаанд илүү буюу дутуу даралттай ус авах хүсэлт тавибал хангагчийн зөвшөөрлөөр гэрээнд зохицуулалт хийнэ.

1.5. Аж ахуй нэгж байгууллагуудын гэрээг 2 хувь үйлдэж, хангагч хэрэглэгч байгууллагын эрх бүхий албан тушаалтан баталсан өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

Хоёр. Хангагчийн эрх

2.1 Улсын стандартын норм журмын дагуу цэвэр усаар хангаж, бохир усыг

"ДАРХАН-УС СУВАГ" ХК

татан зайлуулна.

2.2 Хангагч дор дурьдсан нөхцөлд урьдчилан хэрэглэгчид мэдэгдэхгүйгээр цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагаанд хязгаарлалт хийж болно.

а. Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ барилга байгууламжид эрчим хүчний гэнэтийн тасалдал гарсан
 б. Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйл тохиолдовол

2.3 Ус хангамжийг дор дурьдсан нөхцөлд хэрэглэгчид мэдэгдсэнээр зорогсоно.

а. Хангагч байгууллага төлөвлөгөөт урьдчилан засвар хийх
 б. Усны төлбөрийг сардаа багтааж төлөхгүй тохиолдолд
 в. Зөвшөөрөлгүй холболт хийсэн
 г. Техникийн нөхцөл аваагүй холболт хийсэн
 д. Усны тоолуурын баталгаат хугацаа дууссан, тоолуур бүртгүүлзгүй тохиолдолд

2.4 Ус хангамжийг түр зогсоох тухайгаа хангагч 24 цагийн өмнө хэрэглэгчид мэдэгдэнэ.

2.5 Дор дурьдсан нөхцөлд бохир ус нийлүүлэхийг зогсооно. Үүнд:
 а. Нийлүүлсэн бохир ус нь хортой, цацраг идэвхит болон дэлбэрэх, шатах чанартай бодис агуулсан.
 б. Бохир ус нь +30-аас дээш хэмтэй
 в. Бохир ус нь хурц буюу халдварт өвчний нянгаар бохирлогдсон
 г. Ахуйн бохир усны үзүүлэлтүүдийн түвшинд хүртэл урьдчилан цэвэрлээгүй үйлдвэрийн бохир ус буюу хүнд металлын хэмжээ стандарт зөрчсөн тохиолдолд

Гурав. Хэрэглэгчийн үүрэг

3.1 Хэрэглэгч байгууллага нь Монгол Улсын "ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ" хууль, "ТУС ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ, ХЭРЭГЛЭГЧ ХООРОНДЫН АЖ АХУЙН ХАРИЛЦААНЫ ДҮРЭМ", "ХЭМЖИЛ ЗҮЙН ТУХАЙ" хууль болон бусад хууль стандарт норм дүрмүүдийг судлах.

3.2 Усны тоолуурын зангилааг MNS ISO 4064-2-2013 стандарт, Дотор сантехникийн систем БНБД 40-06-16 барилгын норм ба дүрмийн дагуу тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

3.3 Хэрэглэгч нь цэвэр усны шугамын оруулдаг Монгол Улсын стандартад нийцсэн, эрх бүхий байгууллагаар баталгаажсан гэрчилгээтэй усны тоолуурыг ус тусгаарлагчтай, гэрэлтүүлэгчтэй, +5-аас доошгүй хэмтэй өрөөнд буюу дулаан үзэлийн өрөөнд суурилуулна.

"ДАРХАН-УС СУВАГ" ХК

3.4 Хэрэглэгч нь усны тоолуур эвдэрсэн, гацсан тохиолдолд хангагчид мэдэгдэж яаралтай засварлах арга хэмжээ авна. Мөн хангагч байгууллага байгууллагад мэдэгдэлгүй лац тасалж, тоолуур салгасан тохиолдолд алданги тооцож журмын дагуу торгууль ногдуулна.

3.5 Хэрэглэгч нь усны тоолуурын баталгаат хугацаа дууссан даруй мэргэжлийн байгууллагад хандан баталгаажуулна. Айл өрх 6 жилд нэг удаа, ААН-үүд 2 жилд нэг удаа баталгаажилтанд оруулна.

3.6 Хэрэглэгч нь өөрийн эзэмшилд байгаа шугам хоолой, хаалт арматурт засвар үйлчилгээг өөрийн хөрөнгөөр хийж усны алдагдалгүй байлгана. Усны алдагдал гарсан тохиолдолд алдаж байгаа шугамын хөндлөн огтлолоор бодож хэрэглэсэн усны төлбөр дээр нэмж төлнө.

3.7 Хэмжил зүйн улсын байцаагч, улсын шалгагч болон Дархан-Ус суваг ХК-ийн эрх бүхий ажилтанг тоолуурын өрөөнд саадгүй нэвтрүүлнэ. /Гүлхүүрийг бэлэн байлгах/

3.8 Хэрэглэгч нь үйлдвэрлэл, үйл ажиллагааны төлөвлөгөөт хүчин чадал өөрчлөгдөх, хаягийн бүртгэл солигдох, шугам сүлжээний схем өөрчлөх, байршил шилжих зэрэг тохиолдолд 7 хоногийн дотор хангагчид мэдэгдэнэ.

3.9 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж, усны хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, Монгол улсын "Хот суурин умсц хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 15.1.8, 15.1.9, 15.1.10 заалтуудыг мөрдөж ажиллана.

3.10 Хэрэглэгч үйлдвэрлэлийн явцад гарч буй бохир усыг MNS6561: 2015 стандартад тохирох хэмжээнд хүртэл саармагжуулан төв шугаманд нийлүүлнэ.

3.11 Мэргэжлийн байгууллагаас дээж авахад үйлдвэрт саадгүй нэвтрүүлэх.

Дөрөв. Төлбөр тооцооны журам

4.1 Хэрэглэгчийн хэрэглэсэн цэвэр усны хэмжээг хэмжүүрийн заалтаар тооцно. Хэрэв хэмжих хэрэгсэлтэй боловч баталгаажуулагдаагүй, хүчин чадал, нарийвчлан ангилал тохироогүй хэмжүүр ашигласан, лац тэмдэг хөдөлгөсөн, зөвшөөрөлгүй холболт хийсэн, санаатай тоолуур зогсоосон, тойрог шугамаар зөвшөөрөлгүй холболт хийсэн, санаатай тоолуур зогсоосон, тойрог шугамаар зөвшөөрөлгүй ус авсан бол шугамын оруулгын хөндлөн огтлолоор секундэд 1,5м/сек хурдтай усыг сүүлийн бичилт хийсэн өдрөөс хойших хугацаанд тасралтгүй авч байснаар тооцно.

4.2 Хэмжүүрийг баталгаажуулахаар буюу өөр бусад шалтгаанаар усны хэмжүүрийн заалтыг бүртгэж тохиолдолд усны тооцоог өмнөх 3 сарын дундаж дүнгээр 2 дахь сараас усны тоолуур дахин шинээр тавих хүртэлх хугацаанд аж ахуйн гэрээний дагуу задгайгаар тооцож мөрдөгдөнө.

4.3 Хэрэглэгч нь усны зүй бус хэрэглээ болон бусад зөрчил гаргасан тохиолдолд "Зүй бус хэрэглээнд алданги тооцох журам"-ын дагуу

“ДАРХАН-УС СУВАГ” ХК

алданги тооцно.

4.4 Усны тоолуургүй хэрэглэгчийн хэрэглэсэн усны хэмжээг төрийн захиргааны төв байгууллагаар батлагдсан ус хэрэглээний жишиг нормыг үндэслэн задгайгаар тооцно.

4.5 Ариутгах татуургад нийлүүлэгдэж байгаа бохир усны хэмжээг тооцохдоо цэвэр усны хэрэглээг үндэслэнэ. Зарим үйлдвэрийн газруудын бүтээгдэхүүнд шингэсэн усны хэмжээг хасаж бохир усны хэмжээг тооцно.

4.6 Халуун усны задгай системтэй аж ахуй нэгжийн бохир усны хэмжээг хэрэглэсэн цэвэр усны 20-50 хувиар нэмэгдүүлж тооцно. Халуун усны тоолууртай тохиолдолд тоолуурын заалтаар, тоолуургүй хэрэглэгчийг аж ахуй гэж үзэхийг 50 хувиар тооцно.

4.7 Хэрэглэгч нь Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2014 оны 12-р сарын 25-ны өдрийн 78 тоот тогтоолын дагуу суурь үнийг тоолуурын оролтын шугамаар тооцож төлнө.

4.8 Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн тогтоолын дагуу цэвэр, бохир усны үнэ тарифыг мөрдөж ажиллана.

Тав. Хариуцлага

5.1 Хэрэглэгч усны төлбөрийг хангагчаас тавьсан төлбөрийн нэхэмжлэлийг авснаас хойш 15 хоногийн дотор төлнө. /Тухайн сардаа багтааж/

5.2 Усны төлбөрийн хугацаа хэтэрвэл хугацаа хэтэрсэн хоног тутамд нийт үнийн дүнгийн 0.5%-тай тэнцэх алданги ноогдуулна.

5.3 Хэрэглэгч өөр байгууллагын мэдэлд шилжих, өөрсдийн хүсэлтээр усны хангамжийг зогсоох тохиолдолд хангагчид урьдчилан мэдэгдэж аж ахуйн гэрээг шинэчлэн хийнэ.

5.4 Хангагч, хэрэглэгчийн хооронд гарсан маргаантай асуудлыг харилцан шийдвэрлэж чадаагүй тохиолдолд холбогдох хууль хяналтын байгууллага болон шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.5 Хэрэглэгч үйлдвэрлэлийн явцад гарсан бохир усны стандартыг зөрчсөн тохиолдолд ус бохирдуулсны төлбөрийн тухай Дархан-Уул аймгийн Засаг даргийн 01-А/27 захирамжийг хангаж ажиллах.

5.6 Ариутгах татуургын шугам сүлжээнд нийлүүлсэн хаягдал ус нь ерөнхий шаардлага MNS6561 2015 стандартыг хангаагүй бохир усыг нийлүүлсэн тохиолдолд хангагч байгууллага усны хэрэглээг хязгаарлана.

“ДАРХАН-УС СУВАГ” ХК

ГЭРЭЭ ЗӨВШӨӨРЧ БАЙГУУЛСАН

Хэрэглэгчийн итгэмжилсэн төлөөлөгч

Албан тушаал: Аж ахуйн инженер

Овог нэр: Н. Шинэ

Улсын бүртгэлийн №: 19/100/10000

НӨАТ төлөгчийн регистрийн №: дс 00 463

Харилцах утас:

Байгууллагын e-mail хаяг:

Хариуцах банкны дугаар:

Үйл ажиллагааны чиглэл:

Төсөв	
Аж ахуйн нэгж:	
Машин угаалга	
Худалдаа	
Зочид буудал	
Зоогийн газар, ресторан	
Үйлдвэрлэл:	
Архи пиво	
Талх нарийн боов	
Мах махан бүтээгдэхүүн	
Арьс, шир	
Түүхий эд боловсруулах	
Хүнд үйлдвэрлэл	
Бохирдуулагч үйлдвэр	

Холболт:

Цэвэр ус:	
Төвлөрсөн системээс	
Гэр хорооллын шугам	<input checked="" type="checkbox"/>
Гүний худагтай	
Зөвөрөөр	
Бохир ус:	
Төвийн коллекторт	<input checked="" type="checkbox"/>
Цооногтой	
Бохиргүй	

“ДАРХАН-УС СУВАГ” ХК

Хэрэглэсэн усанд төлбөр тавих хугацаа: Сар Улирал

Гэрээний төрөл: Түр Байнгын

Гэрээ өөрчлөх болсон шалтгаан:

Хэрэглэгчийг төлөөлж гарын үсэг:

Хангагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч
 Албан тушаал: Хяналтын инженер
 Овог нэр: Н. Шинэ
 Гарын үсэг: Н. Шинэ
 2023 оны 10 сарын 10 өдөр

Төлбөр тооцох тариф

№	Яндангийн голч /мм/	Усны хурд м3/сек	Зардалын м3/сар	Суурь хураамж /төг/
1	15	1.5	911	
2	20	1.5	1218	
3	25	1.5	1903	
4	32	1.5	3112	<u>15180</u>
5	40	1.5	4872	
6	50	1.5	7612	
7	80	1.5	19487	
8	100	1.5	30449	
9	25	1.5	42576	
10	150	1.5	68510	
11	200	1.5	121795	
12	250	1.5	190306	
13	300	1.5	274039	

“ДАРХАН-УС СУВАГ” ХК

Батлав: Дархан-Уул аймгийн захирал Г.Эрдэнэбат

Батлав: Дархан-Уул аймгийн захирал Г.Эрдэнэбат

Цэвэр, бохир усны 2023 оны 10 сарын 10 тоот гэрээний жилийн хэрэглээний тооцоо

Нөгр.төрөл	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	Жилийн дүн
Хүйтэн ус м ³ /	1000	1000	1000	1000	4000
Халуун ус м ³ /	1000	1000	1000	1000	4000
Бохир ус м ³ /	1000	1000	1000	1000	4000

Тодотгол: Н. Шинэ тус тус харилцан томирч хийв.

Хэрэглэгчийг төлөөлж: Н. Шинэ ажигтай
 Овогтой: Н. Шинэ
 Гарын үсэг: Н. Шинэ

Хангагчийг төлөөлж: Н. Шинэ ажигтай
 Овогтой: Н. Шинэ
 Гарын үсэг: Н. Шинэ

Энэхүү гэрээ нь 2023 оны 10 сарын 10 өдөр хүртэл хүчинтэй

Зураг 13. Цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх гэрээ

НАЙМ. ТУХАЙН ЖИЛИЙН ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

ОХШХ-ийн хүрээнд үйлдвэрийн талбай орчмоос агаарын чанарын болон хөрсний бохирдлын дээжийг жил бүр авч шинжлүүлж байна.



ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

№ 17/2023

2023 оны 06 дугаар сарын 09

Дархан-Уул

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 **Гэрээний зорилго:** Орчны бохирдлын эх үүсвэр бүхий үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны орчны байгаль орчинд гарч болох хими, физик, биологийн хувьсал өөрчлөлт, агаар, усан мандал, хөрсний бохирдолтын түвшинд байгаль орчны ажиглалт, судалгаа, хяналт шинжилгээ хийж, дүгнэлт өгөх
- 1.2 Монгол улсын агаарын тухай хуулийн 9.1.3; 9.1.4 заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10.1-3, 11.2 заалтын дагуу агаар бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн байгууллагаар орчны бохирдлын хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгүүлсэн байна.
Нэг талаас: **Дархан-Уул аймгийн УЦУОШТөв /РД:9023291/-ийг төлөөлж** УОШХ-ийн дарга М.Алимаа /цаашид гүйцэтгэгч гэх/,
Нөгөө талаас: **“Силиткат” ХК /РД:2050463/-ийг төлөөлж** **Володя овогтой Мөнхтуяа** /цаашид захиалагч гэх/ нар нь “Дархан-Уул аймгийн Хонгор сум 2 дугаар багийн нутаг дэвсгэр Асгат уул-ийн Шохойн чулууны ордын үйлдвэрлэлийн орчны хяналт шинжилгээний ажлыг жилд 1 удаа гүйцэтгүүлэхээр энэхүү гэрээг байгуулав. Энэхүү гэрээ нь 4 жилийн хугацаанд хүчинтэй болно.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

- 2.1. Орчны хяналт шинжилгээний ажил заавар, удирдамжийн дагуу явагдаж байгаа явцад хяналт тавих, шаардах
- 2.2. Захиалагч тал тухайн хугацааны сорьц, дээж авах үеийн унааны асуудлыг хариуцаж шийдвэрлэх
- 2.3. Шинжилгээний ажлын эцэст сорилтын үр дүнг шалгаж хүлээн авах
- 2.4. Гэрээт ажлын төлбөрийг хугацаанд нь төлөх

Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 3.1. Итгэмжлэгдсэн лабораторийн үйл ажиллагааг сорилтын лабораторид тавигдах MNS ISO/IEC17025:2018 стандартын шаардлагад нийцүүлэн MNS, MNS ISO стандарт, аргачлалын дагуу заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэх
- 3.2. Гүйцэтгэгч нь лабораторийн нэрийн өмнөөс үйлчилгээ гүйцэтгэх явцад тухайн байгууллагаас авсан бүх мэдээллийн нууцыг хадгалах
- 3.3. Шинжилгээний үр дүнд ямар нэгэн эргэлзээтэй дүн мэдээ гарсан тохиолдолд түүнийг засах, давтан шинжилгээ хийх ба ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга, нээлттэй байх бүрэн хариуцлага хүлээх

- 3.4. Шинжилгээний дүнг итгэмжлэгдсэн лабораторийн “Сорилтын дүнгийн тайлан”-гаар баталгаажуулж хүргүүлэх
- 3.5. Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад хүндэтгэх шалтгаанаар түр зогсоох, хойшлуулах зэрэг тохиолдолд захиалагчид нэн даруй мэдэгдэж өөрсдийн зүгээс шаардлагатай арга хэмжээг авах

Дөрөв. Шинжилгээний ажлын хөтөлбөр

4.1. Агаар орчны бохирдлын хяналт шинжилгээ

Сорьц авах цэг: Үйлдвэрлэлийн орчинд

Тодорхойлох үзүүлэлтүүд:

А. Агаар дахь азотын давхар исэл /NO₂/

Б. Агаар дахь хүхэрлэг хий /SO₂/

В. Агаар дахь PM10, PM2.5, нийт тоосонцрын агууламж

4.2. Усны химийн шинжилгээ:

Сорьц авах цэг:

А. Технологийн ус

Тодорхойлох үзүүлэлтүүд:

Усны химийн шинжилгээний 19 үзүүлэлт /хавсралтаар/

4.3. Хөрсний бохирдлын хяналт шинжилгээ

Сорьц авах цэг: Үйлдвэрлэлийн орчинд

Тодорхойлох үзүүлэлтүүд: А. Хөрсөн дэх агрохимийн бохирдол

Б. Хүнд металлын бохирдол

Тав. Төлбөр тооцоо

- 5.1. Шинжилгээний төлбөрийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/164 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Орчны чанарын хяналт шинжилгээний ажлын үйлчилгээний хөлс, үнэ тариф”-ын дагуу тооцно.
- 5.2. Шинжилгээний ажлын төлбөрийг Дархан-Уул аймаг УЦУОШТөв, регистр 9023291, Төрийн сан банк, дансны нэр: **Да.УЦУОШТөв 100190013015** тоот дансанд ажлын 10 хоногт төвлөрүүлнэ.
- 5.3. Төлбөрийг барагдуулсны дараа “Сорилтын дүнгийн тайлан”-г хүргүүлнэ.
- 5.4. Захиалагчаас заасан шинжилгээний үзүүлэлтүүдийн тоо, төлбөрийн талаарх тооцоог жил бүрийн эцэст тооцож гүйцэтгэгчийн санхүүтэй тайлант хугацааны эцэст тооцоо нийлж гэрээ дүгнэсэн акт үйлдэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙГ ТӨЛӨӨЛЖ: УОШХ-ИЙН ДАРГА

..... М.АЛИМАА

УТАС: 99378302

Email: alima.m8302@gmail.com

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ:

..... В.ХУЛАН

УТАС: 99405027

Email: hulangsu9@gmail.com

“СИЛИКАТ” ХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ДАРГА *Ц.Содбилэг* Ц.СОДБИЛЭГ

УТАС 99053485

Email: agvaanaa9932@gmail.com

НЯГТЛАН БОДОГЧ:

С.Золбоотөгс С.ЗОЛБООТӨГС

УТАС: 8007055

Email:

Зураг 14. ОХШХ-ийг хэрэгжүүлэх ажил гүйцэтгэх гэрээ

Огноо/Date: 2023.10.25 13:29:52				
Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information				
Журналын/Journal No: 000571168957				
Системийн огноо/System Date: 2023.10.25 13:29:52				
Дт/From	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5086105463	СИЛИКАТ	157,800.00 MNT	1.00
/ Нэг зуун тавин долоон мянга найман зуун төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No	Банкны нэр/Bank Name		
	90	State Fund - Төрийн Сан	157,800.00 MNT	1.00
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Нэр/Name		
	100190013015	Да.УЦУОШТөв		
Гүйлгээний утга/Transaction description: ЕВ-Силикат ХК-с шинжилгээний төлбөр				

Зураг 15. ОХШХ-ийн төлбөр төлсөн баримт

ЕС. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 7. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Зардал, мян.төг
Энэхүү тайлангийн сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх	Хэрэгжүүлж ажилласан.
Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулах	Ажилчиддаа хөдөлмөр хамгаалал авулгүй ажиллагааны сургалтыг мэргэжлийн байгууллагаар жил бүр зохион байгуулж сургалтанд хамруулсан.
Ажиллагсдыг тоосноос хамгаалах хошуувч, хувцас хэрэгслээр хангах	Ажиллагсдыг тоосноос хамгаалах хошуувч, хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.
Газрын төлөв байдлын улсын чанарын хянан баталгаа хийлгэж, дүгнэлт гаргуулах	Газрын төлөв байдал чанарын хянан баталгааг Эхлэх Цэг Хангай ХХК-гаар хийлгэж, дүгнэлт гаргуулан ажилласан.



Зураг 16. ХХАА-ны хувцас хэрэгслээр хангасан байдал

АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАСАН БАЙДАЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулан БОАЖЯ-ны цахим системд цаг хугацаанд нь илгээсэн болно.

ДҮГНЭЛТ

Манай компани нь 2023 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Тоосжилтын хяналтыг ажлын байранд тогтмол хийж, түүхий эд тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь тоосжилт үүсэхээс сэргийлж хучлагатай тээвэрлэлт хийн ажилласан.
- ✓ Ногоон байгууламжийг нэмэгдүүлж, Силикат ХК-ийн эзэмшлийн Сайханы элс нэртэй талбайд 576 ш хайлаас мод тарьсан
- ✓ Үйлдвэрийн цех тасаг бүрт гал түймрийн булан байрлуулж ажилласан.
- ✓ Хог хаягдлын гэрээ байгуулж, гэрээний дагуу тээвэрлүүлж байсан.
- ✓ Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаар, хөрс, усны шинжилгээ авч лабораторид шинжлүүлсэн.
- ✓ Аваар устгах төлөвлөгөөг Дархан Уул аймгийн онцгой байдлын газраар батлуулан ажиллаж байна.
- ✓ Дархан ус суваг ХК-тай жил бүр гэрээ байгуулан шинжилгээ хийлгэн ажилласан.
- ✓ Байгаль орчны аудит хийлгэж дүгнэлт гаргуулсан.

2023 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр хийгдэх ёстой ажлуудыг цаг тухайд нь хийж гүйцэтгэхийг хичээн ажилласан болно.